

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын 2 дугаар цэцэрлэг 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2026/62/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Дархан-Уул аймаг

2026 он

Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр:

Утас: 70378845

Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Аудитын менежер: У.Батсүрэн

Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn

Ахлах аудитор: С.Батцэцэг

Утас: 70373089

Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Хаан консалтинг аудит ХХК

Гүйцэтгэх захирал: Э.Нандинчимэг

Утас: 88883776

Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	9
5.1 Төлбөрийн акт	10
5.2 Албан шаардлага	10
5.3 Зөвлөмж	10
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	12

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бурхантын гудамж-1,14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 67

танай _____-ны № _____-т

ШАРЫН ГОЛ СУМЫН 2 ДУГААР
ЦЭЦЭРЛЭГЧИЙН ЭРХЛЭГЧИЙН ҮҮРГИЙГ
ТҮР ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ
Д.СЭЛЭНГЭ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Шарын гол сумын 2 дугаар цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын 2 дугаар цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Боловсролын газраас бүх цэцэрлэг, сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд зориулан хэрэгцээт багаж хэрэгсэл болон тоног төхөөрөмжийг нийлүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд тус байгууллага нь хүүхдийн хоол хүнсний бүтээгдэхүүн худалдан авах төлөвлөгөөг батлуулаагүй, тендерийн үйл ажиллагааг зохион байгуулаагүй шууд худалдан авалт хийсэн байна.

Бусад асуудал

4526050199

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Аудитыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн хүрээнд авсан судалгаанд дүн шинжилгээ хийж, эрсдэл бүхий асуудалд анхаарал хандуулсан болно.

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын 2 дугаар цэцэрлэг нь 2025 онд 8 зорилт 30 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 94.0 хувиар тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.МӨНХБАЯР

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/			
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	119,331,254.71	101,518,858.10
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	63,398,808.71	25,581,972.30
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	63,398,808.71	25,581,972.30
31211	Төрийн сангийн харилцах	63,398,808.71	25,581,972.30
35	БАРАА МАТЕРИАЛ	55,932,446.00	75,936,885.80
351	Түүхий эд материал	232,530.00	114,660.00
35130	Эм боох материал	232,530.00	114,660.00
354	Хангамжийн материал	55,699,916.00	75,822,225.80
35410	Бичиг хэргийн материал	19,300.00	106,000.00
35420	Аж ахуйн материал	390,980.00	23,538,970.00
35450	Барилгын засварын материал	597,500.00	-
35460	Хүнсний материал	8,563,225.00	5,122,144.80
35470	Бусад хангамжийн материал	46,128,911.00	47,055,111.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	475,840,739.54	482,821,500.27
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	475,840,739.54	482,821,500.27
392	Биет хөрөнгө	470,116,739.54	477,097,500.27
39201	Барилга, байгууламж, орон сууц	416,383,428.00	416,383,428.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(42,432,696.63)	(51,355,824.39)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	68,982,230.00	75,747,032.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	(30,805,176.86)	(21,096,536.74)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	36,099,228.75	37,436,398.75
39208	Хуримтлагдсан элэгдэл	(19,680,810.47)	(17,802,526.10)
39209	Зам, гүүрийн байгууламж	15,865,600.54	15,865,600.54
39210	Хуримтлагдсан элэгдэл	(2,433,263.79)	(2,869,072.23)
39214	Бусад үндсэн хөрөнгө	27,015,000.00	28,475,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(110,000.00)	(3,686,000.06)
39217	Ном	1,233,200.00	-
393	Биет бус хөрөнгө	5,724,000.00	5,724,000.00
39301	Програм хангамж	1,124,300.00	1,124,300.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,124,300.00)	(1,124,300.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	5,724,000.00	5,724,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	595,171,994.25	584,340,358.37
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	595,171,994.25	584,340,358.37
51	Засгийн газрын хувь оролцоо	595,171,994.25	584,340,358.37
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	76,438,124.13	76,438,124.13
51101	Өмч: - төрийн	76,438,124.13	76,438,124.13
512	Хуримтлагдсан үр дүн	402,778,239.24	391,946,603.36
51210	Өмнөх үеийн үр дүн	402,778,239.24	402,778,239.24
51220	Тайлант үеийн үр дүн	-	(10,831,635.88)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	115,955,630.88	115,955,630.88
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	595,171,994.25	584,340,358.37

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	782,435,630.00	863,749,107.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	47,821,030.00	50,523,507.50
120	Нийтлэг татварын бус орлого	47,821,030.00	50,523,507.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,000,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,000,000.00	-

120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	42,424,500.00	30,045,287.50
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	396,530.00	20,478,220.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	734,614,600.00	813,225,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	680,314,600.00	744,811,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	680,314,600.00	744,811,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	54,300,000.00	68,414,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	54,300,000.00	68,414,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	692,018,151.73	873,347,543.38
21	УРСГАЛ ЗАРДАЛ	692,018,151.73	873,347,543.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	686,560,990.54	873,346,813.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	505,773,775.62	651,692,356.67
210101	Үндсэн цалин	327,525,317.76	392,081,743.99
210102	Нэмэгдэл	164,321,448.01	224,762,445.25
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	16,856,047.88
210104	Урамшуулал	13,927,009.85	17,992,119.55
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	62,991,327.05	77,801,612.74
210201	Тэтгэврийн даатгал	43,895,120.18	54,330,265.11
210202	Тэтгэмжийн даатгал	4,869,969.28	6,234,424.03
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,408,584.67	3,120,280.81
210204	Ажилгүйдлийн даатгал	2,279,615.69	2,691,079.48
210205	Эрүүл мэндийн даатгал	9,538,037.23	11,425,563.31
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,800,226.81	52,754,469.92
210301	Гэрэл, цахилгаан	4,203,870.36	6,015,107.22
210302	Түлш, халаалт	22,448,783.00	30,996,853.40
210303	Цэвэр, бохир ус	12,147,573.45	15,742,509.30
2104	Хангамж, бараа материалын зардал	-	4,067,800.00
210401	Бичиг хэрэг	-	4,067,800.00
2105	Нормативт зардал	38,462,330.00	38,644,996.20
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	85,000.00	618,820.00
210502	Хоол, хүнс	38,377,330.00	38,026,176.20
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,600,852.00	10,829,300.00
210604	Урсгал засвар	7,600,852.00	10,829,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	662,200.00	1,951,581.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	662,200.00	1,951,581.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,270,279.06	35,604,696.77
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,155,000.00	6,501,570.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,469,000.00	961,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	20,646,279.06	28,141,326.77
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,457,161.19	730.08
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,457,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,457,000.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	161.19	730.08
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	161.19	730.08
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	90,417,478.27	(9,598,435.88)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	1,233,200.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	1,233,200.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(1,233,200.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	90,417,478.27	(10,831,635.88)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
------------	----------	----------	------------

	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>739,614,600.00</u>	<u>813,225,600.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,000,000.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	5,000,000.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,000,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,000,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	734,614,600.00	813,225,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	680,314,600.00	744,811,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	680,314,600.00	744,811,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	54,300,000.00	68,414,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	54,300,000.00	68,414,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>680,292,222.67</u>	<u>844,732,436.41</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>680,292,222.67</u>	<u>844,732,436.41</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>674,835,061.48</u>	<u>844,731,706.33</u>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	505,773,775.62	651,692,356.67
210101	Үндсэн цалин	347,549,848.02	392,081,743.99
210102	Нэмэгдэл	144,296,917.75	224,762,445.25
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	16,856,047.88
210104	Урамшуулал	13,927,009.85	17,992,119.55
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	62,991,327.05	77,801,612.74
210201	Тэтгэврийн даатгал	43,895,120.18	54,330,265.11
210202	Тэтгэмжийн даатгал	4,869,969.28	6,234,424.03
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,408,584.67	3,120,280.81
210204	Ажилгүйдлийн даатгал	2,279,615.69	2,691,079.48
210205	Эрүүл мэндийн даатгал	9,538,037.23	11,425,563.31
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,076,836.21	52,754,469.92
210301	Гэрэл, цахилгаан	4,203,870.36	6,015,107.22
210302	Түлш, халаалт	22,448,783.00	30,996,853.40
210303	Цэвэр, бохир ус	11,424,182.85	15,742,509.30
2105	Нормативт зардал	42,289,400.00	34,585,096.00
210502	Хоол, хүнс	42,289,400.00	34,585,096.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,484,612.00	9,718,800.00
210604	Урсгал засвар	7,484,612.00	9,718,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	662,200.00	1,951,581.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	662,200.00	1,951,581.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,556,910.60	16,227,790.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,102,910.60	11,109,490.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,454,000.00	5,118,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	<u>5,457,161.19</u>	<u>730.08</u>
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,457,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,457,000.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	161.19	730.08
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	161.19	730.08
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>59,322,377.33</u>	<u>(31,506,836.41)</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	15,135,100.00	6,310,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	15,135,100.00	6,310,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	15,135,100.00	6,310,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	15,135,100.00	6,310,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(15,135,100.00)</u>	<u>(6,310,000.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	44,187,277.33	(37,816,836.41)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	19,211,531.38	63,398,808.71
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	63,398,808.71	25,581,972.30

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	76,438,124.13	115,955,630.88	312,360,760.97	504,754,515.98
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	76,438,124.13	115,955,630.88	312,360,760.97	504,754,515.98
Тайлант үеийн үр дүн	-	-	90,417,478.27	90,417,478.27
2024 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	76,438,124.13	115,955,630.88	402,778,239.24	595,171,994.25
2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	76,438,124.13	115,955,630.88	402,778,239.24	595,171,994.25
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	76,438,124.13	115,955,630.88	402,778,239.24	595,171,994.25
Тайлант үеийн үр дүн	-	-	(10,831,635.88)	(10,831,635.88)
2025 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	76,438,124.13	115,955,630.88	391,946,603.36	584,340,358.37

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	747,896,100.00	744,811,600.00	3,084,500.00
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	747,896,100.00	744,811,600.00	3,084,500.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	747,896,100.00	744,811,600.00	3,084,500.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	747,896,100.00	744,811,600.00	3,084,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	807,072,300.00	782,628,436.41	24,443,863.59
21	УРСГАЛ ЗАРДАЛ	807,072,300.00	782,628,436.41	24,443,863.59
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	790,190,300.00	766,030,646.41	24,159,653.59
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	662,540,700.00	651,692,356.67	10,848,343.33
210101	Үндсэн цалин	411,236,500.00	392,081,743.99	19,154,756.01
210102	Нэмэгдэл	236,055,800.00	224,762,445.25	11,293,354.75
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	16,856,047.88	(16,856,047.88)
210104	Урамшуулал	15,248,400.00	17,992,119.55	(2,743,719.55)
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	82,377,300.00	77,801,612.74	4,575,687.26
210201	Тэтгэврийн даатгал	55,875,700.00	54,330,265.11	1,545,434.89
210202	Тэтгэмжийн даатгал	6,625,400.00	6,234,424.03	390,975.97
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,312,700.00	3,120,280.81	192,419.19
210204	Ажилгүйдлийн даатгал	3,312,700.00	2,691,079.48	621,620.52
210205	Эрүүл мэндийн даатгал	13,250,800.00	11,425,563.31	1,825,236.69
2105	Нормативд зардал	42,275,800.00	34,585,096.00	7,690,704.00
210502	Хоол хүнс	42,275,800.00	34,585,096.00	7,690,704.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,996,500.00	1,951,581.00	1,044,919.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээ	2,996,500.00	1,951,581.00	1,044,919.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,882,000.00	16,597,790.00	284,210.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,754,700.00	11,479,490.00	275,210.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,127,300.00	5,118,300.00	9,000.00
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	63,398,808.71	63,398,808.71	-
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		25,581,972.30	(25,581,972.30)
5	АЖИЛЛАГСДЫН ТОО	42	41	1
6	Удирдах ажилтан	1	1	-
7	Гүйцэтгэх ажилтан	14	13	1
8	Үйлчлэх ажилтан	6	6	-

2.6 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	74,243,800.00	68,413,269.92	5,830,530.08
21	УРСГАЛ ЗАРДАЛ	74,243,800.00	68,413,269.92	5,830,530.08
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	74,243,800.00	68,413,269.92	5,830,530.08
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	58,405,000.00	52,754,469.92	5,650,530.08
210301	Гэрэл, цахилгаан	6,917,100.00	6,015,107.22	901,992.78
210302	Түлш, халаалт	35,369,900.00	30,996,853.40	4,373,046.60
210303	Цэвэр, бохир ус	16,118,000.00	15,742,509.30	375,490.70
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,838,800.00	15,658,800.00	180,000.00
210604	Урсгал засвар	15,838,800.00	15,658,800.00	180,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	74,243,800.00	68,413,269.92	5,830,530.08
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	74,243,800.00	68,413,269.92	5,830,530.08
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	74,243,800.00	68,413,269.92	5,830,530.08

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,233.2 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөөс бараа материал ангилалд шилжүүлэхдээ дээд байгууллагын шийдвэрээс өөр ангилалд 1,233.2 мянган төгрөгийн бараа материалыг бүртгэж, тайлагнасан нь “УСНББОУС 1 Санхүүгийн тайлагналын толилуулга”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", "Санхүүгийн тайлангийн толилуулга" батламж мэдэгдлийг хангаагүй тул аудитын явцад санхүүгийн байдлын тайлангийн бараа материал дансанд бүртгэж залруулав.

Мөн аудитаар нийт 31,444.8 мянган төгрөгийн зөрчил² илэрсэн тул 1 төлбөрийн акт, 1 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүллээ. Үүнд:

5.1 Төлбөрийн акт

Тайлант онд тус цэцэрлэгийн бараа, үйлчилгээний бусад зардлаас хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан эрхлэгч М.Энхмаад сургалтын төлбөрт 520.7 мянган төгрөг төлж, батлагдсан төсвийг үр ашиггүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 39 дүгээр тогтоолоор баталсан "Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам"-ын хавсралт "Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хэмжээний бүрэлдэхүүн, зардлын зориулалт, эдийн засгийн ангиллын дэлгэрэнгүй заавар"-ын 3-д "Багшийн хөгжил буюу мэргэжил дээшлүүлэх зардалд цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны хөгжих хэрэгцээнд суурилсан цахим платформд түшиглэн явуулах тусгай сургалт (1, 5, 10 жилийн сургалтаас бусад), бусад сургалт үйл ажиллагааны зардал багтана" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

5.2 Албан шаардлага

Тайлант онд тус цэцэрлэгийн эрхлэгч М.Энхмаа нь Дархан-Уул аймгийн Боловсролын газрын даргын 2025 оны А/94 дүгээр тушаалыг үндэслэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдэл цалин хөлсөнд нийт 675.8 мянган төгрөг авч, хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д "Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын захирал /эзэн/, ажил олгогч шууд хариуцна", 27.6-д "Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтцийн жишиг, ажилтны орон тооны норматив, зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална", Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/114 дүгээр тушаалын 1.В хэсэгт "Төрийн болон төрийн үйлчилгээний төсвийн байгууллага ажилтны тооноос хамаарахгүйгээр Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг аль нэг ажилтанд хавсран хариуцуулна. Хавсран ажиллуулсан тохиолдолд Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлд заасны дагуу үндсэн ажлын цалингийн 40 хүртэлх хувийн нэмэгдэл хөлс олгоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.3.1 Цалингийн зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Албан хаагчдын илүү цагийн хөлс 30,248.3 мянган төгрөгийг баталсан маягтын дагуу тооцоогүй, баталгаажуулж баримтжуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтөлж,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 3 дугаар зүйлийн 1-д "Төрийн албан хаагч энэ журмын хавсралтаар баталсан "Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас"-ны дагуу илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласан үндэслэл, гүйцэтгэсэн ажлын гол агуулга, нэмэгдүүлсэн цалин хөлсний тооцоог нэгжийн даргаар хянуулж баталгаажуулсны үндсэн дээр байгууллагын дарга зөвшөөрөл олгосны дараа санхүүд хүргүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 3 дугаар зүйлийн 1 дэх заалтыг баримталж, анхан шатны баримтыг бүрдүүлж ажиллах.

Дээрх тайлангийн 3.5.5 дахь хэсэгт дурдсан Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилд өгсөн албан шаардлага, 4.4.1 дэх хэсэгт дурдсан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчилд өгсөн хариуцлага тооцох албан шаардлага, 5.1 дэх хэсэгт дурдсан төлбөрийн акт, 5.2 дахь хэсэгт дурдсан албан шаардлага, 5.3 дахь хэсэгт дурдсан зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5³-д заасны дагуу ирүүлэх, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

³ Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан **зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор** төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгөөс бараа материал ангилалд шилжүүлэхдээ дээд байгууллагын шийдвэрээс өөр ангилалд мянган төгрөгийн бараа материалыг бүртгэж, тайлагнасан	1	1,233.2	-	-	1	1,233.2	1	1,233.2	-	-	-	-
Дүн	1	1,233.2	-	-	1	1,233.2	1	1,233.2	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Тайлбар
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	
Тайлант онд тус цэцэрлэгийн бараа, үйлчилгээний бусад зардлаас хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан эрхлэгч М.Энхмаад сургалтын төлбөр төлж, батлагдсан төсвийг үр ашиггүй зарцуулсан.	1	520.7	1	520.7	-	-	-	-	-	-	
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдэл цалин хөлс авч, хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй	1	675.8	-	-	1	675.8	-	-	-	-	
Албан хаагчдын илүү цагийн хөлсийг баталсан маягтын дагуу тооцоогүй, баталгаажуулж баримтжуулаагүй	1	30,248.3	-	-	-	-	1	30,248.3	-	-	
Дүн	3	31,444.8	1	520.7	1	675.8	1	30,248.3	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс		Зөвлөмж	
							Тоо	Дүн		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш орлогын 46,525.0 мянган төгрөгийн 8 мэдээллийг байршуулаагүй	1	46,525.0	-	-	1	46,525.0	-	-	-	-

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Хүүхдийн хоол хүнсний худалдан авалтын төлөвлөгөө батлаагүй, тендер зарлаагүй шууд худалдан авалт хийсэн байна.	1	42,275.8			1	42,275.8		
Дүн	2	88,800.8	-	-	2	88,800.8	-	-